

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/06/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 93032714

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

|   |    |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....     | 3  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....                        | 3  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....                     | 4  |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                         | 5  |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....          | 6  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                                 | 7  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....                                 | 8  |
| 3. Аудитын тайлан .....   | 9  |
| 3.1. Ерөнхий зүйл.....  | 9  |
| 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....                     | 9  |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....                   | 9  |
| 3.4 Материаллаг байдал .....  | 10 |
| 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....                                 | 10 |
| 3.5.1 Мөнгөн хөрөнгө .....  | 10 |
| 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....                                      | 10 |
| 3.5.3 Авлага .....  | 10 |
| 3.5.4 Урьдчилгаа .....  | 11 |
| 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....   | 11 |
| 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ .....  | 11 |
| 3.5.7 Үндсэн хөрөнгө.....   | 12 |
| 3.5.8 Өр төлбөр.....  | 12 |
| 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....  | 12 |
| 3.5.10 Орлогын данс.....  | 13 |
| 3.5.11 Зардлын данс.....  | 13 |
| 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                         | 14 |
| 3.7 Шилэн дансны мэдээлэл.....  | 15 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....                | 16 |
| 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....                    | 16 |
| 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... | 17 |
| 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....  | 17 |
| 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....                            | 18 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт            |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                 |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ      | Төсвийн төвлөрүүлэн захирагч                                |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                                       |



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.04.06 № 363

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын санал дүгнэлт гаргах тухай**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023033632

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|----------------|-----------------|
| 1          | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   | 630,659.2      | 906,698.0       |
| 31         | МӨНГӨН ХӨРӨНГӨ  | 107,658.1      | 321,646.1       |
| 33         | АВЛАГА  | 271,559.0      | 240,062.2       |
| 34         | УРЬДЧИЛГАА  | -              | 1,860.0         |
| 35         | БАРАА МАТЕРИАЛ  | 251,442.1      | 341,129.7       |
| 36         | НӨӨЦИЙН БАРАА   | -              | 2,000.0         |
| 2          | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   | 3,192,188.1    | 3,349,463.3     |
| 39         | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 3,192,188.1    | 3,349,463.3     |
| 392        | Биет хөрөнгө  | 3,037,021.8    | 3,194,739.3     |
| 393        | Биет бус хөрөнгө  | 155,166.3      | 154,724.0       |
| 3          | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II   | 3,822,847.3    | 4,256,161.3     |
| 4          | НИЙТ ӨР ТӨЛБӨР  | 72,179.3       | 31,006.8        |
| 41         | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 72,179.3       | 31,006.8        |
| 413        | Өглөг   | 72,179.3       | 31,006.8        |
| 5          | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  | 3,750,668.0    | 4,225,154.5     |
| 51         | Засгийн газрын хувь оролцоо   | 3,750,668.0    | 4,225,154.5     |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,758,554.0    | 1,758,554.0     |
| 512        | Хуримтлагдсан үр дүн  | 1,606,530.2    | 2,081,016.7     |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 385,583.8      | 385,583.8       |
| 6          | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V                           | 3,822,847.3    | 4,256,161.3     |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          | 2,956,294.7         | 4,399,692.9           |
| 11         | ТАТВАРЫН ОРЛОГО  | 150,876.2           | 528,947.0             |
| 110        | Орлогын албан татвар                                     | 73,414.0            | 61,231.7              |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                          | 73,414.0            | 61,231.7              |
| 113        | Хөрөнгийн албан татвар                                   | 3,450.0             | 87,912.9              |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 74,012.1            | 379,802.4             |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 866,666.4           | 462,798.7             |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                              | 866,666.4           | 462,798.7             |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 1,938,752.1         | 3,407,947.2           |
| 2          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 2,327,023.0         | 3,697,735.0           |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  | 2,327,023.0         | 3,697,735.0           |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 2,260,253.1         | 2,377,994.1           |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,218,666.6         | 1,270,595.4           |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 149,198.6           | 165,627.9             |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 240,589.6           | 229,706.1             |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 76,546.6            | 63,355.3              |
| 2105       | Нормативт зардал   | 76,503.5            | 91,534.3              |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 26,644.2            | 20,148.5              |
| 2107       | Томилот, зочны зардал                                    | 5,818.0             | 9,586.0               |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 190,623.5           | 150,085.7             |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 275,662.5           | 377,354.8             |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 66,769.9            | 1,319,740.9           |
| 3          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)                       | 629,271.7           | 701,957.9             |
| 225        | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                          | 94,070.1            | 230,971.4             |
| 5          | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)                                  | 535,201.7           | 470,986.5             |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|---------------------|-----------------------|
| 1          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)                              | 2,319,723.5         | 4,168,238.2           |
| 11         | ТАТВАРЫН ОРЛОГО   | 150,876.2           | 528,947.0             |
| 110        | Орлогын албан татвар  | 73,414.0            | 61,231.7              |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                                     | 73,414.0            | 61,231.7              |
| 113        | Хөрөнгийн албан татвар  | 3,450.0             | 87,912.9              |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                                       | 74,012.1            | 379,802.4             |
| 1180       | Бусад нийтлэг төлбөр, хураамж                                       | 21,090.8            | 31,726.3              |
| 1181       | Газрын төлбөр   | 10,993.6            | 8,288.6               |
| 1182       | Байгалийн нөөц ашигласны төлбөр                                     | 41,927.7            | 339,787.5             |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО   | 230,095.2           | 250,674.7             |
| 120        | Нийтлэг татварын бус орлого   | 230,095.2           | 250,674.7             |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                       | 1,938,752.1         | 3,388,616.4           |
| 2          | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)                               | 2,139,181.7         | 3,512,553.9           |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ   | 2,139,181.7         | 3,512,553.9           |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                     | 2,076,436.7         | 2,187,875.2           |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                   | 1,238,507.6         | 1,311,800.1           |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                      | 150,554.3           | 167,791.8             |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                           | 170,151.0           | 287,792.4             |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                                    | 195,252.9           | 95,603.0              |
| 2105       | Нормативт зардал  | 70,925.6            | 103,600.3             |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                                   | 30,163.7            | 34,958.7              |
| 2107       | Томилолт, зочны зардал  | 5,790.0             | 9,586.0               |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж            | 124,867.1           | 90,851.1              |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                                     | 90,224.6            | 85,891.9              |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | 62,744.9            | 1,324,678.7           |
| 3          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)                    | 180,541.8           | 655,684.3             |
| 5          | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)                           | 199,545.1           | 436,696.3             |
| 22         | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ  | 199,545.1           | 436,696.3             |
| 2200       | Дотоод эх үүсвэрээр   | 199,545.1           | 436,696.3             |
| 6          | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (199,545.1)         | (436,696.3)           |
| 23         | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ                          | 55,000.0            | 5,000.0               |
| 7          | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ                     | (55,000.0)          | (5,000.0)             |
| 8          | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)                           | (74,003.3)          | 213,988.0             |
| 9          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                    | 181,661.4           | 107,658.1             |
| 10         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                   | 107,658.1           | 321,646.1             |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| №  | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| 1  | <b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 1,758,554.0                     | 385,583.8             | 1,066,372.1       | -     | 3,210,509.9                            |
| 2  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | 4,956.5           | -     | 4,956.5                                |
| 3  | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | 1,758,554.0                     | 385,583.8             | 1,071,328.6       | -     | 3,215,466.4                            |
| 4  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт          | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 5  | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 6  | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 7  | Өмчид гарсан өөрчилөлт                           |                                 |                       |                   |       |  |
| 8  | Зарласан ногдол ашиг                             |                                 |                       |                   |       |  |
| 9  | Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 535,201.7         | -     | 535,201.7                              |
| 10 | <b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 1,758,554.0                     | 385,583.8             | 1,606,530.2       | -     | 3,750,668.0                            |
| 11 | <b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 1,758,554.0                     | 385,583.8             | 1,606,530.2       | -     | 3,750,668.0                            |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | -                               | -                     | 3,500.0           | -     | 3,500.0                                |
| 13 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | 1,758,554.0                     | 385,583.8             | 1,610,030.2       | -     | 3,754,168.0                            |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | -                               | -                     | -                 | -     | -                                      |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт                           |                                 |                       |                   |       |  |
| 18 | Зарласан ногдол ашиг                             |                                 |                       |                   |       |  |
| 19 | Тайлант үеийн үр дүн                             | -                               | -                     | 470,986.5         | -     | 470,986.5                              |
| 20 | <b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 1,758,554.0                     | 385,583.8             | 2,081,016.7       | -     | 4,225,154.5                            |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт   | Тайлант оны           |             |
|-----------------------|--|-----------------------|-------------|
|                       |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл   |
| 2                     | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 2,677,306.5           | 2,440,285.3 |
| 21                    | УРСГАЛ ЗАРДАЛ  | 2,200,567.6           | 2,082,340.4 |
| 210                   | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 2,164,039.8           | 2,054,966.7 |
| 2101                  | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,283,910.7           | 1,244,045.6 |
| 2102                  | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 168,601.5             | 162,242.6   |
| 2103                  | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 293,120.0             | 285,306.4   |
| 2104                  | Хангамж, бараа материалын зардал                         | 52,886.3              | 52,471.5    |
| 2105                  | Нормативт зардал   | 105,008.5             | 61,410.8    |
| 2106                  | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 91,367.1              | 91,288.5    |
| 2107                  | Томилолт, зочны зардал                                   | 9,125.4               | 8,886.0     |
| 2108                  | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 98,204.7              | 92,155.1    |
| 2109                  | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 61,815.6              | 57,160.3    |
| 213                   | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 36,527.8              | 27,373.8    |
| 2132                  | Бусад урсгал шилжүүлэг                                   | 36,527.8              | 27,373.8    |
| 22                    | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 402,738.9             | 352,944.9   |
| 2200                  | Дотоод эх үүсвэрээр                                      | 402,738.9             | 352,944.9   |
| 23                    | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ               | 74,000.0              | 5,000.0     |
| 13                    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 2,677,306.5           | 2,560,665.7 |
| 1310                  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                                  | 1,267,016.0           | 1,166,404.7 |
| 1320                  | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 1,293,285.1           | 1,281,572.4 |
| 1340                  | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ             | 21,858.6              | 20,843.3    |
| 4                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | -                     | 37,733.9    |
| 5                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | -                     | 158,114.2   |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт   | Гүйцэтгэл |
|------------|--|-----------|
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 162,973.7 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  | 162,973.7 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 134,398.8 |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 28,669.8  |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 3,609.1   |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 4,377.4   |
| 2105       | Нормативт зардал   | 42,189.5  |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 16,233.8  |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 700.0     |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,581.7   |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 34,551.4  |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 28,574.9  |
| 2132       | Бусад урсгал шилжүүлэг                                   | 28,270.0  |
| 2133       | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 304.9     |
| II         | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                           | 162,973.7 |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 162,973.7 |

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Л.Цэнгэл танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Жаргалтхаан сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөгүй байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Төсвийн тухай хуульд “Төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ гэж тодорхойлсон. Төсвийн тухай хуулийн 5.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан байна Үүнд:

15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

#### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3,210.5 сая төгрөгийн 1 хувь буюу 32.1 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 24.1 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 107.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 321.6 сая төгрөг болж, 213.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|----------------------------|----------------|-----------------|------------------------|-----------------|
| Касст байгаа бэлэн мөнгө   |                |                 |                        |                 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 107.7          | 319.4           | 211.7                  | 99.3            |
| Замд яваа мөнгөн хөрөнгө   | -              | 2.2             | 2.2                    | 0.7             |
| Хадгаламж                  |                |                 |                        |                 |
| <b>Дүн</b>                 | <b>107.7</b>   | <b>321.6</b>    | <b>213.9</b>           | <b>100%</b>     |

*Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 318.9 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 0.5 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн төвийн 1.7 сая төгрөг, тусгай сангуудын 156.4 сая төгрөг, сумын орлогын ерөнхий дансны 160.8 сая төгрөг, арилжааны банкны үлдэгдэлд Эмийн эргэлтийн сан, Жаргалтхаан тохижилт үйлчилгээний 0.5 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 2.2 сая төгрөг байгаа нь оны эцэст орсон хөрөнгийн орлого, малд ногдох албан татвар, газрын төлбөртэй холбоотой мөнгөн хөрөнгө байна.

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт данс үлдэгдэлгүй байна.

#### 3.5.3 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 271.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 240.0 сая төгрөг болж, 31.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт                        | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---------------------------------|----------------|-----------------|------------------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.2            | 2.4             | 2.2                    |
| Төлбөртэй үйлчилгээний авлага   | -              | 35.2            | 35.2                   |
| Бусад авлага                    | 1.0            | 1.0             | -                      |
| Зээлийн авлага                  | 270.3          | 201.4           | (68.9)                 |
| <b>Дүн</b>                      | <b>271.5</b>   | <b>240.0</b>    | <b>-31.5</b>           |

Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ажиллагчидтай холбогдсон авлагын үлдэгдлийн 0.3 сая төгрөг Засаг даргын тамгын газрын, 2.1 сая төгрөг Ерөнхий боловсролын сургуулийн авлага байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагын 35.2 сая төгрөг Эрүүл мэндийн төвийн даатгалын сангаас авах дутуу санхүүжилт, бусад авлага дансны 1.0 сая төгрөг Засаг даргын тамгын газрын 0.7 сая төгрөг, Цэцэрлэгийн 0.2 сая төгрөг, Соёлын төвийн 0.1 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

Зээлийн авлага тайлант онд 5.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 73.9 сая төгрөгөөр хорогдож 201.4 сая төгрөг үлдсэн байна. Зээлийн авлагын 154.3 сая төгрөгийн үлдэгдэл нь хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл байна.

**Аудитын илрүүлэлт: Авлагын данстай холбоотой доорх зөрчил гарсан.**

Соёлын төвийн мөнгөн гүйлгээний журналаас цалинд олгосон дүнг цалингийн анхан шатны баримттай тулгахад 0.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан байна.

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 1.9 сая төгрөг болж өссөн байна.

*Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт               | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|------------------------|----------------|-----------------|---------------------------|
| Урьдчилж гарсан зардал |                | 1.9             | 1.9                       |
| <b>Дүн</b>             | <b>-</b>       | <b>1.9</b>      | <b>-</b>                  |

Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлбөрийг урьдчилж шилжүүлсэн зардал байна.

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 251.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 343.1 сая төгрөг болж, 91.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт            | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|---------------------|----------------|-----------------|---------------------------|
| Түүхий эд материал  | 27.1           | 51.5            | 24.4                      |
| Бэлэн бүтээгдэхүүн  |                |                 | 0.0                       |
| Хангамжийн материал | 195.1          | 269.7           | 74.6                      |
| Мал амьтад          | 29.2           | 21.9            | -7.3                      |
| <b>Дүн</b>          | <b>251.4</b>   | <b>343.1</b>    | <b>91.7</b>               |

Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын 392.1 сая төгрөгийн орлого авснаас 381.5 сая төгрөгийг худалдан авч, 6.8 сая төгрөгийг хандиваар, 3.8 сая төгрөгийг шилжүүлэн авсан байна.

*Аудитын илрүүлэлт: Бараа материалын данстай холбоотой доорх зөрчил гарсан байна.*

*Ерөнхий боловсролын сургуулийн малын тайланд сүргийн эргэлт хийгээгүйгээс 0.8 сая төлийн орлогыг орхигдуулсан байсныг аудитын явцад залруулсан.*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,192.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,349.4 сая төгрөг болж, 157.2 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|------------------|----------------|-----------------|------------------------|
| Биет хөрөнгө     | 3,037.0        | 3,194.7         | 157.7                  |
| Биет бус хөрөнгө | 155.2          | 154.7           | (0.5)                  |
| <b>Дүн</b>       | <b>3,192.2</b> | <b>3,349.4</b>  | <b>157.2</b>           |

*Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 207.7 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 154.5 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 91.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 121.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

*Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой 2.5 сая төгрөгийн зөрчил гарсан байна.*

*Цэцэрлэг нь хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 72.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 31.0 сая төгрөг болж, 41.1 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

| Үзүүлэлт                             | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|--------------------------------------|----------------|-----------------|------------------|-----------------|
| Байгууллагад төлөх өглөг             | 62.8           |                 | <b>(62.80)</b>   | 152.80          |
| Дансны өглөг /ТӨҮГ/                  | 9.3            | 31.0            | <b>21.70</b>     | (52.80)         |
| <b>Богино хугацаат өр төлбөр дүн</b> | <b>72.1</b>    | <b>31.0</b>     | <b>(41.1)</b>    | <b>100.0</b>    |

*Эх сурвалж: Жаргалтхаан сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 31.0 сая төгрөг Эмийн эргэлтийн сангийн эмийн өглөг байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,750.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,225.2 сая төгрөг болж, 474.5 сая төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

| Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/,-/ бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|--|----------------|-----------------|-------------------------|-----------------|
| <b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b> | <b>1,758.6</b> | <b>1,758.6</b>  | -                       | -               |
| Өмч /төрийн/   | 1,758.6        | 1,758.6         | -                       | -               |
| Хуримтлагдсан үр дүн   | 1,606.5        | 2,081.0         | <b>474.5</b>            | 100.00          |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү   | 385.6          | 385.6           | -                       |                 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү   |                |                 | -                       |                 |
| Бодлогын өөрчлөлт алдааны залруулга  |                |                 | -                       |                 |
| <b>Дүн</b>   | <b>3,750.7</b> | <b>4,225.2</b>  | <b>474.5</b>            | <b>100.0</b>    |

*Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Хуримтлагдсан үр дүн 4,225.2 сая төгрөг болж 474.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгийн өсөлттэй холбоотой байна.

### 3.5.10 Орлогын данс

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 49.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 7.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 81.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогыг 10.3 сая төгрөгөөр бүрдүүлсэн байна.

*Аудитын илрүүлэлт: Орлогын данстай холбоотой 20.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:*

*Засаг даргын тамгын газрын төсвийн орлогод төвлөрүүлэх бэлчээрийн төлбөрийн 1.6 сая төгрөгийг байгууллагын нэмэлт дансанд орлого авч зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.*

*Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжаад гарсан эмийн эргэлтийн эмийн сангийн эмийн хөнгөлөлтийн 15.7 сая төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээнийг аудитын явцад залруулсан.*

*Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн орлогын төлөвлөгөө 2.8 сая төгрөгөөр тасарсан зөрчилд зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.*

### 3.5.11 Зардлын данс

Үйл ажиллагаанд нийт 3,928.7 сая төгрөгийн зардал гарснаас цалин шимтгэлд 1,468.2 сая төгрөг буюу 37.4 хувь, тогтмол зардалд 230.3 сая төгрөг буюу 5.9 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 105.1 сая төгрөг буюу 2.7 хувь бараа үйлчилгээний бусад зардалд 377.4 сая төгрөг буюу 9.6 хувь, урсгал шилжүүлэгт 1,320.0 сая төгрөг буюу 33.5 хувийг тус тус зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт: Зардлын данстай холбоотой 27.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:*

*Засаг даргын тамгын газрын малчинд үндсэн үйл ажиллагааны зардлаас 1.5 сая төгрөгийн цалин олгосон, батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 4.0 сая төгрөгийн тавилга худалдаж авсан зөрчилд албан шаардлага хүргүүлж, цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 2.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн зөрчлийг аудитын явцад залруулсан.*

*Ерөнхий боловсролын сургуулийн батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 3.5 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.9 сая төгрөгийн сургалтын төлбөрийг урьдчилан шилжүүлж, шууд зардалд бүртгэсэн, 13.6*

сая төгрөгийн бараа материалын зарлагыг цалингийн зардалд бүртгэсэн зөрчлүүдийг аудитын явцад залруулсан байна.

Цэцэрлэгийн 0.8 сая төгрөгийн ө баримтгүй худалдан авалт хийж, гүйлгээ хийсэн зөрчилд зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Жаргалтхаан сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 01 дугаар тогтоолд зааснаар Жаргалтхаан сумын Засаг даргын тайлант онд 454.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 605.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 151.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

| Орлогын төрөл  | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү        | Хувь         |
|--|--------------|--------------|--------------|--------------|
| Үйл ажиллагааны орлого   | 20.0         | 25.7         | 5.7          | 128.4        |
| Хөрөнгийн орлого   | 24.0         | 33.0         | 9.0          | 137.5        |
| Хөрөнгө борлуулсаны орлого                                     | 0.0          | 2.5          | 2.5          |              |
| Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал | 0.5          | 0.0          | -0.5         | 0.0          |
| Бууны албан татвар   | 3.3          | 3.1          | -0.2         | 95.0         |
| Малд ногдох албан татвар                                       | 60.0         | 84.8         | 24.8         | 141.3        |
| Улсын тэмдэгтийн хураамж                                       | 1.8          | 2.0          | 0.2          | 113.3        |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр              | 8.0          | 7.6          | -0.5         | 94.4         |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж                              | 20.0         | 22.1         | 2.1          | 110.7        |
| Ойн нөөц ашигласны төлбөр                                      | 3.2          | 11.1         | 7.9          | 345.6        |
| Ус рашаан ашигласны төлбөр                                     | 0.0          | 0.1          | 0.1          |              |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр                                | 246.7        | 328.6        | 81.9         | 133.2        |
| Газрын төлбөрийн орлого  | 10.0         | 8.3          | -1.7         | 82.9         |
| Торгуулийн орлого  | 50.0         | 63.0         | 13.0         | 126.0        |
| Бусад орлого   | 6.5          | 13.2         | 6.7          | 202.9        |
| <b>Нийт дүн</b>  | <b>454.0</b> | <b>605.2</b> | <b>151.1</b> | <b>133.3</b> |

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 151.1 сая төгрөгөөр давж биелсэн боловч, зарим нэр төрлийн орлого тасарсан байна Үүнд:

Ковид-19 цар тахлын улмаас тэмцээн уралдаан зохион байгуулагдаагүй учраас урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал 0.5 сая төгрөгөөр, хот хоорондын зорчих хөдөлгөөн хязгаарлагдаж иргэн, аж ахуйн нэгж барилгын элс, хайрганы олборлолт багассанаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.5 сая төгрөгөөр, иргэд эзэмшиж байсан галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хийлгээгүйгээс бууны албан татвар 0.1 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 1.7 сая төгрөгөөр нийт 2.8 сая төгрөгөөр биелээгүй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 217.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн орлогыг 236.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 454.0 сая төгрөгөөр баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,677.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,385.9 сая төгрөгийг урсгал зардалд, 208.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 83.2 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,267.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,156.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 21.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 136.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 95.1 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,267.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,156.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 20.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 136.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 81.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 32.0 сая төгрөгөөр биелсэн нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 10.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 3.0 сая төгрөгөөр биелсэн нь Байгал хамгаалах сангийн орлогоор биелсэн бөгөөд Засаг даргын тамгын газрын орлого 0.4 сая төгрөгөөр биелээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,440.3 сая төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалин, шимтгэл, тогтмол зардал, нормативт зардал, хөрөнгийн зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын 6 ажил, их засварын 2 ажил, өмнөх оны дутуу 1 ажлыг 204.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр төлөвлөсөн ажлыг дуусган 161.0 сая төгрөг зарцуулсан байна

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 100.7 сая төгрөгийг улсын төсөвт, 11.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 0.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 132.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30.3 сая төгрөг, нийт 149.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд 32.3 сая төгрөг, тогтмол зардалд 2.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 4.4 сая төгрөг, нормативт зардалд 42.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 16.2 сая төгрөг, томиллод 0.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 1.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 34.6 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 28.3 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 0.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

## 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

**Аудитын илрүүлэлт: Шилэн данстай холбоотой 375.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:**

Засаг даргын тамгын газар шилэн дансанд мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 20.0 сая төгрөгийн 2, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 171.8 сая төгрөгийн 7 гүйлгээ нийт 191.8 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургууль таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг 38.3 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн төв таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 49.1 сая төгрөгийн 59 мэдээ, мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 345.6 сая төгрөгийн 48 мэдээ, мэдээллийг мэдээлж, 144.9 сая төгрөгийн 11 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрсэн. Уг зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Цэцэрлэг тайлант онд мэдээлбэл зохих 144 мэдээллийг байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 удаагийн 0.2 сая төгрөгийн авлагыг мэдээлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 0.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 244.9 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |              | Биелэлт  |              | Биелэгдээгүй |     | Хэрэгжилтийн хувь |
|-----------------|---------------------|--------------|----------|--------------|--------------|-----|-------------------|
|                 | Тоо                 | Дүн          | Тоо      | Дүн          | Тоо          | Дүн | Хувь              |
| Албан шаардлага | 1                   | 0.5          | 1        | 0.5          |              |     | 100%              |
| Зөвлөмж         | 4                   | 244.9        | 4        | 244.9        |              |     | 100%              |
| <b>Нийт</b>     | <b>5</b>            | <b>245.4</b> | <b>5</b> | <b>245.4</b> | -            | -   |                   |

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 13 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан тус сумын харьяа Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын дунд сургууль, Соёлын төвийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна. Цэцэрлэгийн санхүүгийн тайланд хувийн аудитын “Өндөрхаан итгэл аудит” компани аудит хийж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг зөрүүгүй нэгтгэсэн байна.

#### Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Акт, албан шаардлага өгөгдөөгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 423.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 34.1 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 243.4 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 145.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

### **3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Орон нутгийн орлогын төвлөрүүлэлттэй холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөг 2.8 сая төгрөгөөр тасалсан байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлгүй төлөвлөдөг, орлогын төлөвлөгөө биелүүлээгүй байх.

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж, орлогыг төлөвлөгөөг биелүүлэн ажиллах.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.**

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

|                                     |   |                                    |   |
|-------------------------------------|---|------------------------------------|---|
| <b>Огноо:</b><br>2022.04.17         | <b>Аудитын нэр:</b>                                 | <b>Санхүүгийн тайлангийн аудит</b> | <b>Аудитын код:</b><br>ХЭА-2022/06/НА-СТА-ТТЗ |
| <b>Шалгагдсан байгууллагын нэр:</b> | <b>Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг дарга</b> |                                    | <b>Сая төгрөгөөр</b>                          |

| №   | Алдаа, зөрчлийн товч утга  | Мөнгөн дүн   | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                            |
|---|--|--------------|---------------------------------------|---|----------------------------|
|   |  |              | Нэр                                   | Албан тушаал                                      | Овог нэр                   |
| 1   | Төсвийн орлогод төвлөрүүлэх бэлчээрийн төлбөрийн 1.6 сая төгрөгийг байгууллагын нэмэлт дансанд орлого авч зарцуулсан.  | 1.6          | Албан шаардлага                       | Дарга Нягтлан бодогч                              | С.Мөнхдэлгэр<br>З.Жанчив   |
| 2   | Малчинд үндсэн үйл ажиллагааны зардлаас 1.5 сая төгрөгийн цалин олгосон.   | 1.5          | Албан шаардлага                       | Дарга Нягтлан бодогч                              | С.Мөнхдэлгэр<br>З.Жанчив   |
| 3   | Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 4.0 сая төгрөгийн тавилга худалдаж авсан.   | 4.1          | Албан шаардлага                       | Дарга Нягтлан бодогч                              | С.Мөнхдэлгэр<br>З.Жанчив   |
| 4   | Шилэн дансанд мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 20.0 сая төгрөгийн 2, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 171.8 сая төгрөгийн 7 гүйлгээ нийт 191.8 сая төгрөгийн 9 гүйлгээг мэдээлээгүй байна. | 191.8        | Албан шаардлага                       | Нягтлан бодогч                                    | З.Жанчив                   |
| 5   | Цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд 2.1 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн.  | 2.1          | Залруулга хийсэн.                     | Дарга Нягтлан бодогч                              | З.Жанчив                   |
| <b>Засаг даргын тамгын газрын алдаа, зөрчлийн дүн</b>     |  | <b>201.1</b> |                                       |   |                            |
| 1   | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг дутуу мэдээлсэн.   | 38.3         | Албан шаардлага                       | Захирал Нягтлан бодогч                            | Г.Төмөрбаатар<br>Г.Урансүх |
| 2   | Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал зөрчин зарцуулсан.  | 3.5          | Албан шаардлага                       | Захирал Нягтлан бодогч                            | Г.Төмөрбаатар<br>Г.Урансүх |
| 3   | Сургалтын төлбөрийг урьдчилан шилжүүлж, шууд зардалд бичсэн.   | 1.9          | Залруулга хийсэн.                     | Нягтлан бодогч                                    | Г.Урансүх                  |
| 4   | Малын тайланд сүргийн эргэлт хийгдээгүй.   | 0.8          | Залруулга хийсэн.                     | Нягтлан бодогч                                    | Г.Урансүх                  |
| 5   | Бараа материалын зарлагыг цалингийн зардалд бүртгэсэн.   | 13.6         | Залруулга хийсэн.                     | Нягтлан бодогч                                    | Г.Урансүх                  |
| <b>Ерөнхий боловсролын сургуулийн алдаа, зөрчлийн дүн</b> |  | <b>58.0</b>  |                                       |   |                            |

|   |   |              |                   |                            |                              |
|---|---|--------------|-------------------|----------------------------|------------------------------|
| 1   | 0.8 сая төгрөгийн худалдан авалтыг Е баримтгүй мөнгөн зарлага хийсэн.   | 0.8          | Зөвлөмж өгсөн.    | Эрхлэгч Нягтлан бодогч     | С.Алтанцэцэг<br>Г.Урансүх    |
| 2   | Мэдээлбэл зохих 144 мэдээллийг байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 удаагийн 0.2 сая төгрөгийн авлагыг мэдээлээгүй байна.   | 0.2          | Зөвлөмж өгсөн.    | Эрхлэгч Нягтлан бодогч     | С.Алтанцэцэг<br>Г.Урансүх    |
| 3   | Хичээл үйлдвэрлэлийн зардлаас 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.  | 2.5          | Албан шаардлага   | Эрхлэгч Нягтлан бодогч     | С.Алтанцэцэг<br>Г.Урансүх    |
| <b>Цэцэрлэгийн алдаа, зөрчлийн дүн</b>          |   | <b>3.6</b>   |                   |                            |                              |
| 1   | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 490540.9 мянган төгрөгийн 59 мэдээ, мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 345680.2 мянган төгрөгийн 48 мэдээ, мэдээллийг мэдээлж, 144860.7 мянган төгрөгийн 11 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрлээ. Мэдээллийг 70.5 хувьтай мэдээлсэн байна. | 144.9        | Зөвлөмж өгсөн.    | Дарга Нягтлан бодогч       | Н.Түвшинжаргал<br>Г.Сэргэлэн |
| 2   | Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжаад гарсан эмийн эргэлтийн эмийн сангийн эмийн хөнгөлөлтийн санхүүжилтийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.  | 15.7         | Залруулга хийсэн. | Нягтлан бодогч             | Г.Сэргэлэн                   |
| <b>Эрүүл мэндийн төвийн алдаа, зөрчлийн дүн</b> |   | <b>160.6</b> |                   |                            |                              |
| 1   | Мөнгөн гүйлгээний журналаас цалинд олгосон дүнг тооцсон цалингийн анхан шатны баримттай тулган шалгах, дахин тооцоолоход 133.2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн боловч авлагаар тусгаагүй байна.   | 0.1          | Залруулга хийсэн. | Дарга Нягтлан бодогч       | Н.Энхтунгалаг<br>З.Жанчив    |
| 2   | Татварын орлогын төлөвлөгөөг тасалсан.  | 2.8          | Зөвлөмж өгсөн.    | Засаг дарга Нягтлан бодогч | Л.Цэнгэл<br>Э.Эрдэнэхүү      |
| <b>Засаг даргын алдаа, зөрчлийн дүн</b>         |   | <b>2.9</b>   |                   |                            |                              |
| <b>Нийт алдаа, зөрчлийн дүн</b>                 |   | <b>426.2</b> |                   |                            |                              |